



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/3/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	<table><tr><td>Тэргүүлэх аудитор:</td><td>Т.Ган-Өлзий</td></tr><tr><td>Утас: 70522734</td><td>Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn</td></tr><tr><td>Аудитын менежер:</td><td>У.Оюунтүлхүүр</td></tr><tr><td>Утас: 70523020</td><td>Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn</td></tr><tr><td>Багийн ахлагч аудитор:</td><td>Ш.Сувдаа</td></tr><tr><td></td><td>Цахим хаяг: smaudit97@gmail.com</td></tr></table>	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа		Цахим хаяг: smaudit97@gmail.com
Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий												
Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn												
Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр												
Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn												
Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа												
	Цахим хаяг: smaudit97@gmail.com												

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.03.15 № 16/323

танай _____-ны № _____-т

ЭМ ЭРГЭЛТИЙН САН ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЭРХЭМБОЛД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	478.2	636.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	97.5	100.4
	Нийт хөрөнгийн дүн	575.8	736.9
	Нийт өр төлбөрийн дүн	282.3	507.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	293.5	229.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	293.5	229.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,811.7	2,267.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,892.0	2,330.2
	Үйл ажиллагааны үр дүн	62.6	61.9
	Үйл ажиллагааны бус үр дүн		2.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	62.6	63.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189.6	189.6
	Тайлант оны үр дүн	102.1	38.1
	Эцсийн үлдэгдэл	293.5	229.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,042.0	2,566.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,028.0	2,540.1
	Үйл ажиллагааны ЦМГ	13.9	26.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(8.4)	(8.6)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5.4	17.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3.0	8.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8.4	25.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ нь Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 98 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 дугаар захирамжаар байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Аймгийн нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /эрх зүйн акт/-тай нийцэж байна.

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин, урамшуулал олгоогүй.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд арга хэмжээ аваагүй байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцолсон асуудал гараагүй болно.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 22 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эм эргэлтийн сан ОНӨААТҮГ нь тайлант онд нийт т өсвийн гүйцэтгэлийн 4 улирлын мэдээлэл, санхүүгийн тайлан 2, аудитын тайланд хийгдсэн аудитын дүгнэлт 1, тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл 4, тухай бүр мэдээлэх 14 мэдээллээс 11 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Шилэн дансанд нийт 135 ширхэг 641040.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ, 1,012,936.6 мянган төгрөгийн 27 багцын тендерийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 29.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 29.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлан, татварын тайлангийн зөрүү 13.4 сая төгрөгийн борлуулалтын орлогыг санхүүгийн тайланд тусгав.
- Татварын тайлантай холбоотой ААНБООАТ 2.0 сая төгрөгийг залруулав.
- НӨАТ 1.3 сая төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулав.
- Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын ТТ-11 тайланд санхүүгийн тайлангаас зөрүүтэй тайлагнасан 12.3 сая төгрөгийн залруулга хийлээ.

Зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгийг актлах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ОНӨ	1	1			1			
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ОНӨ	5	29.1	5	29.1					1	0
	НИЙТ	5	29.1	5	29.1	-	-			1	0